

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/187/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024-02-27 № 1-6/212

танай _____-ны № _____-т

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.АРИУНАА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гурав дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Сургуулийн барилга болон бусад үндсэн хөрөнгүүдийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 19.95 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй тайлан бэлтгэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

010000047

Ебаримт-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 52 ширхэг 653,5 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 17 ширхэг 28.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй.

Зурагт ухаалаг 4к /Neolux65 инч/, Лазер хэвлэгч машин гэх мэт хөрөнгүүдийг шууд худалдан авалт хийсэн ба цахим дэлгүүрт хандаагүй, тухайн жилийнхээ худалдан авах хөрөнгийн жагсаалтыг цахим дэлгүүрт илгээгээгүй.

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн зэрэг асуудлууд нь үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 93 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	328,285,330.02	589,124,584.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	51,720,491.65	338,176,805.39
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	51,720,491.65	338,176,805.39
31210	Төгрөг	51,720,491.65	338,176,805.39
31211	Төрийн сангийн харилцах	46,371,171.03	329,483,011.77
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	5,349,320.62	8,693,793.62
33	АВЛАГА	470,026.78	163,008.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	470,026.78	102,984.00
33500	Бусад авлага	0.00	60,024.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	60,024.00
35	БАРАА МАТЕРИАЛ	276,094,811.59	250,784,771.50
35100	Түүхий эд материал	48,498,091.08	49,485,741.08
35110	Тусгай зориулалттай материал	48,488,191.08	49,438,191.08
35130	Эм боох материал	9,900.00	47,550.00
35400	Хангамжийн материал	224,431,720.51	198,134,030.42
35410	Бичиг хэргийн материал	22,600,448.00	4,146,431.00
35420	Аж ахуйн материал	138,179,303.01	125,004,635.30
35450	Барилгын засварын материал	2,521,400.00	2,227,700.00
35470	Бусад хангамжийн материал	59,980,569.50	66,755,264.12
35600	Мал амьтад	3,165,000.00	3,165,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,907,033,479.40	4,282,985,178.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,907,033,479.40	4,282,985,178.69
39200	Биет хөрөнгө	3,714,457,812.52	4,090,841,261.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,578,291,000.00	3,968,426,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-268,371,824.94	-329,635,571.19
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	287,157,422.07	474,497,422.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,169,614.25	-133,996,042.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	213,885,307.10	228,485,307.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-54,237,626.46	-142,078,122.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,640,000.00	2,640,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,156,000.00	-2,640,000.00
39217	Ном	21,419,149.00	25,142,169.00
39300	Биет бус хөрөнгө	192,575,666.88	192,143,916.96
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,151,333.12	-1,583,083.04
39303	Бусад биет бус хөрөнгө	192,000,000.00	192,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,235,318,809.42	4,872,109,763.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	87.30	235,605.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	87.30	235,605.96
41300	Өглөг	87.30	235,605.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	235,605.96
41360	Бусад өглөг	87.30	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	87.30	0.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,235,318,722.12	4,871,874,157.62
51	Засгийн газрын хувь оролцоо	4,235,318,722.12	4,871,874,157.62
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,770,291,000.00	3,770,291,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,770,291,000.00	3,770,291,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	465,027,722.12	1,101,583,157.62
51	Өмнөх үеийн үр дүн	3,745,434,164.90	440,059,356.60
51220	Тайлант үеийн үр дүн	4,210,461,887.02	661,523,801.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,235,318,809.42	4,872,109,763.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,488,645,474.63	3,454,103,851.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,123,167,381.59	567,045,068.62
120	Нийтлэг татварын бус орлого	4,123,167,381.59	567,045,068.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	128,797,341.50	52,915,594.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	52,915,594.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	128,797,341.50	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,769,568,423.50	505,768,120.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	224,801,616.59	8,361,354.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,365,478,093.04	2,887,058,782.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,915,465,100.00	2,483,270,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,915,465,100.00	2,483,270,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,336,455.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,876,775.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,459,680.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	414,676,538.04	403,788,382.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	414,676,538.04	403,788,382.65
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,276,786,895.73	2,792,580,050.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,276,786,895.73	2,792,580,050.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,089,408,055.73	2,618,607,300.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,378,678,540.84	1,647,352,056.33
210101	Үндсэн цалин	1,012,729,677.38	1,158,667,059.51
210102	Нэмэгдэл	327,993,782.20	423,788,772.79

210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	22,000.00
210104	Урамшуулал	37,955,081.26	64,874,224.03
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,357,912.07	210,426,728.21
210201	Тэтгэврийн даатгал	120,307,647.22	145,904,222.57
210202	Тэтгэмжийн даатгал	14,350,994.64	17,289,815.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,151,515.48	13,252,632.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,590,812.18	3,089,068.71
210205	Эрүүл мэндийн даатгал	25,956,942.55	30,890,988.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	363,375,837.60	400,790,971.35
210301	Гэрэл, цахилгаан	13,820,409.60	20,880,654.29
210302	Түлш, халаалт	328,440,100.00	354,398,110.06
210303	Цэвэр, бохир ус	21,115,328.00	25,512,207.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,157,628.00	17,337,382.71
210401	Бичиг хэрэг	952,425.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	450,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	348,518.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,406,685.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	17,337,382.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,409,260.00	3,623,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,110,000.00	0.00
210604	Урсгал засвар	10,299,260.00	3,623,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,695,224.50	16,200,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	829,400.00	6,937,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	865,824.50	9,263,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,733,652.72	322,877,011.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,584,806.00	87,225,445.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,381,353.00	40,773,511.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,767,493.72	194,878,055.19
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,626,500.00	129,718,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,752,340.00	44,254,250.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,211,858,578.90	661,523,801.02
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,396,691.88	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,396,691.88	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,210,461,887.02	661,523,801.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,378,787,253.66	2,945,499,249.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,645,615.62	58,440,467.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,645,615.62	58,440,467.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,645,615.62	52,915,594.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,904,755.00	52,915,594.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	6,740,860.62	0.00
120009	Бусад орлого	0.00	5,524,873.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,330,141,638.04	2,887,058,782.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,915,465,100.00	2,483,270,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,915,465,100.00	2,483,270,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	414,676,538.04	403,788,382.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	414,676,538.04	403,788,382.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,229,234,862.01	2,569,012,935.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,229,234,862.01	2,569,012,935.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,041,856,022.01	2,395,040,185.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,382,437,707.35	1,652,274,280.59
210101	Үндсэн цалин	1,016,030,439.11	1,163,022,912.77
210102	Нэмэгдэл	328,452,186.98	424,355,143.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	22,000.00
210104	Урамшуулал	37,955,081.26	64,874,224.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,161,877.86	210,426,728.21
210201	Тэтгэврийн даатгал	120,111,613.01	145,904,222.57
210202	Тэтгэмжийн даатгал	14,350,994.64	17,289,815.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,151,515.48	13,252,632.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,590,812.18	3,089,068.71
210205	Эрүүл мэндийн даатгал	25,956,942.55	30,890,988.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	363,375,750.30	400,791,082.65
210301	Гэрэл, цахилгаан	13,820,322.30	20,880,741.59
210302	Түлш, халаалт	328,440,100.00	354,397,130.06
210303	Цэвэр, бохир ус	21,115,328.00	25,513,211.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,835,300.00	2,997,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,836,500.00	0.00
210604	Урсгал засвар	4,998,800.00	2,997,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,613,224.50	16,200,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,352,400.00	6,937,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,260,824.50	9,263,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,432,162.00	112,350,644.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,996,862.00	88,364,144.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,435,300.00	23,986,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,378,840.00	173,972,750.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	187,378,840.00	173,972,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,626,500.00	129,718,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,752,340.00	44,254,250.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	149,552,391.65	376,486,313.74
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	97,831,900.00	90,030,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,831,900.00	90,030,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	97,831,900.00	90,030,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	97,831,900.00	90,030,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-97,831,900.00	-90,030,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	51,720,491.65	286,456,313.74
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	51,720,491.65
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	51,720,491.65	338,176,805.39

4417144353
EHOA0056 9025707

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,770,291,000.00	-3,745,434,164.90	24,856,835.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,770,291,000.00	-3,745,434,164.90	24,856,835.10
9	Тайлант үеийн үр дүн	0.00	4,210,461,887.02	4,210,461,887.02
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,770,291,000.00	465,027,722.12	4,235,318,722.12
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,770,291,000.00	465,027,722.12	4,235,318,722.12
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-24,968,365.52	-24,968,365.52
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,770,291,000.00	440,059,356.60	4,210,350,356.60
19	Тайлант үеийн үр дүн	0.00	661,523,801.02	661,523,801.02
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	3,770,291,000.00	1,101,583,157.62	4,871,874,157.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,588,422,500.00	2,253,074,153.26	335,348,346.74	0.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,588,422,500.00	2,253,074,153.26	335,348,346.74	0.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,372,716,200.00	2,081,281,803.26	291,434,396.74	0.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,911,114,200.00	1,652,274,280.59	258,839,919.41	0.86
210101	Үндсэн цалин	1,287,453,500.00	1,163,022,912.77	124,430,587.23	0.90
210102	Нэмэгдэл	543,037,500.00	424,355,143.79	118,682,356.21	0.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	22,000.00	-22,000.00	-
210104	Урамшуулал	80,623,200.00	64,874,224.03	15,748,975.97	0.80
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	0.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	238,889,500.00	210,426,728.21	28,462,771.79	0.88
210201	Тэтгэврийн даатгал	162,445,000.00	145,904,222.57	16,540,777.43	0.90
210202	Тэтгэмжийн даатгал	19,111,100.00	17,289,815.98	1,821,284.02	0.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,288,900.00	13,252,632.92	2,036,267.08	0.87
210204	Ажилгүйдлийн даатгал	3,822,200.00	3,089,068.71	733,131.29	0.81
210205	Эрүүл мэндийн даатгал	38,222,300.00	30,890,988.03	7,331,311.97	0.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,784,400.00	202,380,644.46	-3,596,244.46	1.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	174,797,900.00	178,394,144.46	-3,596,244.46	1.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,986,500.00	23,986,500.00	0.00	1.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	215,706,300.00	171,792,350.00	43,913,950.00	0.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	215,706,300.00	171,792,350.00	43,913,950.00	0.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	154,780,700.00	129,718,500.00	25,062,200.00	0.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,925,600.00	42,073,850.00	18,851,750.00	0.69
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,588,422,500.00	2,536,185,994.00	52,236,506.00	0.98
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,483,270,400.00	2,483,270,400.00	0.00	1.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,483,270,400.00	2,483,270,400.00	0.00	1.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	105,152,100.00	52,915,594.00	52,236,506.00	0.50
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,947,200.00	0.00	8,947,200.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,428,400.00	52,915,594.00	-1,487,194.00	1.03
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	44,776,500.00	0.00	44,776,500.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	46,371,171.03	-46,371,171.03	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	329,483,011.77	329,483,011.77	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд нэмэлт санхүүжилт ороогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9 алдаа 664,3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 411,2 сая төгрөгийн алдааг залруулж, 253,1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

- 27 ширхэг камер бараа материалын 18 сая төгрөг дансанд бүртгэсэн байсныг залруулж Үндсэн хөрөнгө дансанд бүртгэснийг залруулав.
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг дахин хийж 18 сая төгрөгийн элэгдлийн зардалыг залруулав.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд шинэчилсэн төлөвлөгөө оруулаагүйгээс бүх зардал илүү зарцуулалттай буруу тайлагнасан 374,сая төгрөгийг залруулав.

5.1 Зөвлөмж

Илрүүлэлт: Батлагдсан төсвийн зардлаас бараа ажил үйлчилгээний зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Илрүүлэлт: Ажилтан Н.Баатархуягын 3 сарын ээлжийн амралтын тооцоог Нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй байгаа нь үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох журмуудыг мөрдөн ажиллах.

Илрүүлэлт: Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 30.4. Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана

30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;

30.4.2.энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах;

30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах гэж хуульд заасан шат дарааллуудыг хэрэгжүүлж ажиллах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлж мэдээллээр хангаж ажиллах

Илрүүлэлт Зурагт ухаалаг 4к /Neolux65 инч/, Лазер хэвлэгч машин гэх мэт хөрөнгүүдийг шууд худалдан авалт хийсэн ба цахим дэлгүүрт хандаагүй, тухайн жилийнхээ худалдан авах хөрөнгийн жагсаалтыг цахим дэлгүүрт илгээгээгүй. Энэ нь үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно гэсэн хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах.

Илрүүлэлт: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 52 ширхэг 653,5 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 17 ширхэг 28.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" Алдаа, стандартын заалт, батламж мэдэгдлийг хангуулах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
27 ширхэг камерийг бараа материалын дансанд бүртгэсэн байсныг залруулж Үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн.	1	18,600.00			1	18,600.00	1	18,600.00		
Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллын дахин хийж залруулав.	1	18,675.73			1	18,675.73	1	18,675.73		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд шинэчилсэн төлөвлөгөө оруулаагүйгээс бүх зардал илүү зарцуулалттай буруу тайлагнасныг залруулав.	1	374,000.00			1	374,000.00	1	374,000.00		
ДҮН	3	411,275.73			3	411,275.73	3	411,275.73	-	-
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл										
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсвийн зардлаас бараа ажил үйлчилгээний зардалыг хэтрүүлэн зарцуулсан.	1	5,095.84					1	5,095.84		
Ажилтан Н.Баатархуягын 3 сарын ээлжийн амралтын мөнгийн Нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй.	1	178.24					1	178.24		
ДҮН	1	5,095.84	-	-	-	-	1	5,095.84	-	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлэлсэн байна.	1						1			
ДҮН	1	-					1	-		

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Евaгimт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 52 ширхэг 653,5 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 17 ширхэг 28.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.	1	28,976.30					1	28,976.30	
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.	1	137,220.00					1	137,220.00	
Зурагт ухаалаг 4к /Neolux65 инч/, Лазер хэвлэгч машин гэх мэт хөрөнгүүдийг шууд худалдан авалт хийсэн ба цахим дэлгүүрт хандаагүй, тухайн жилийнхээ худалдан авах хөрөнгийн жагсаалтыг цахим дэлгүүрт илгээгээгүй.	1	81,630.00					1	81,630.00	
ДҮН	2	247,826.30					3	247,826.30	